

ЗБДС-ийн  
2013...оны  
хуралдааны



**ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН  
БАТЛАН ДААЛТЫН ТӨРӨЛ, ХЭМЖЭЭ,  
ХУГАЦАА, ХУРААМЖ, ШИМТГЭЛ,  
БУСАД НӨХЦӨЛИЙН ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү журмын зорилго нь барьцаа хөрөнгө дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд Зээлийн Батлан Даалтын Сан /цаашид “Сан” гэх/-аас гаргах батлан даалтын төрөл, хэмжээ, хугацаа, хураамж, шимтгэл болон бусад нөхцөлийг тодорхойлоход оршино.
- 1.2. Сангийн батлан даалтын төрөл, хэмжээ, хугацаа, хураамж, шимтгэл болон бусад нөхцөлийг тодорхойлохдоо Монгол улсын “Иргэний хууль”, “Зээлийн батлан даалтын сангийн тухай” хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актыг баримтална.
- 1.3. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.
  - 1.3.1. “Сан” эсхүл “Батлан даагч” гэж барьцаа хөрөнгийн дутагдалтай Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид батлан даалт гаргах үйл ажиллагаа явуулж буй Зээлийн батлан даалтын санг;
  - 1.3.2. “Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч” гэж “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийн 5.1-д заасан этгээдийг;
  - 1.3.3. “Зээл” гэж Зээлдүүлэгчээс Зээлдэгчийн өмчлөлд тодорхой хугацаатайгаар эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг;
  - 1.3.4. “Зээлдүүлэгч” эсхүл “Харилцагч банк, санхүүгийн байгууллага” гэж Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зээл олгож буй, Сантай хамтран ажиллах гэрээ байгуулсан банк, санхүүгийн байгууллагыг;
  - 1.3.5. “Зээлдэгч” гэж Зээлдүүлэгч болон Батлан даагчтай зээлийн болон батлан даалтын гэрээ байгуулахыг хүссэн эсхүл байгуулсан Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг;
  - 1.3.6. “Сангийн батлан даалт” гэж Сан нь Зээлдүүлэгчийн өмнө хариуцлага хүлээх үүргийг гэрээ байгуулах хэлбэрээр өөртөө авсан Сангаас гаргасан баталгааг;
  - 1.3.7. “Үйлчилгээний хураамж” гэж Сангаас үйлчилгээ үзүүлсний төлөө авч буй төлбөрийг;
  - 1.3.8. “Батлан даалтын шимтгэл” гэж Сангаас батлан даалт гаргуулсны төлөө Зээлдэгчийн төлж буй төлбөрийг;
- 1.4. “Зээлийн батлан даалтын сангийн тухай” хуулийн 12 дугаар зүйлд зааснаар Сан нь үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор энэхүү журмын 3.1, 3.2-д заасан батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хураамжийг авна.
- 1.5. Батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хураамжийн хувь хэмжээнд Удирдах зөвлөлийн шийдвэрээр өөрчлөлт оруулж болно.

## **Хоёр. Батлан даалтын төрөл, хэмжээ, хугацаа**

- 2.1. Сан нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаанд зориулж эргэлтийн хөрөнгийн, хөрөнгө оруулалтын, бичил зээлийн гэсэн төрлүүдэд батлан даалт гаргана.
- 2.2. Нэг зээлдэгчид болон “Банкны тухай” хуулийн 3.1.2-т заасан холбогдох этгээдүүдэд гаргах батлан даалтын хэмжээ нь олгох зээлийн 60 хүртэлх хувь буюу Сангийн өөрийн хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй байна.
- 2.3. Батлан даалтын нийт хэмжээ нь сангийн өөрийн хөрөнгийг 20 дахин нэмэгдүүлсэн дүнгээс хэтрэхгүй байна.
- 2.4. Батлан даалтын хугацаа нь Зээлдэгч болон Зээлдүүлэгчийн хооронд байгуулсан зээлийн гэрээний хугацаанаас хэтрэхгүй байна.
- 2.5. Батлан даалтын хугацаа нь батлан даалтын гэрээ байгуулсан өдрөөс эхлэн тооцогдоно.

## **Гурав. Үйлчилгээний хураамж, батлан даалтын шимтгэл**

- 3.1. Батлан даалт гаргуулсан эсэхээс үл хамааран үйлчилгээний хураамж 10000 /арван мянга/ төгрөгийг Санд урьдчилан төлнө.
- 3.2. Батлан даалтын шимтгэлийг батлан даах хугацаанаас хамаарч дараах хувиар тооцож авна. Үүнд:
  - 3.2.1. 1 жил хүртэл хугацаанд - 1.0 %
  - 3.2.2. 1-2 жил хүртэл хугацаанд - 2%
  - 3.2.3. 2 жилээс дээш хугацаанд - 3.0 %
- 3.3. Зээлдэгчид олгох зээлээс батлан даалтын шимтгэлийг суутгаж Сангийн дансанд шилжүүлнэ.

## **Дөрөв. Хариуцлага**

- 4.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдүүдэд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## **Тав. Бусад**

- 5.1. Энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, хүчингүйд тооцох асуудлыг Сангийн Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.